



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/04

Цагаан-Уул сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сумын нөөцийн өвс тэжээл бэлтгэхэд зориулж 33.000.000 (Гучин гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг нөөцөд бэлтгэсэн өвс тэжээл борлуулсан орлогоос төвлөрсөн Засаг даргын Тамгын газрын нэмэлт зарцуулалтын данснаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

3. Нягтлан бодох бүртгэлийн хууль, журмын дагуу санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нярав (Н.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ТҮМЭНБАЯР

